



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/178

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн төвд нэмэлт санхүүжилт
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7, 11.1.8 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 42 дугаар зүйлийн 42.2.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журмын 2.3 дахь хэсэг, Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны А/21 дүгээр тогтоолын 3.2.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эмч нарын нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй түргэн шуурхай үзүүлэх зорилтын хүрээнд дүүргийн Эрүүл мэнд төвд үндсэн эмчээр ажиллах 6 хүртэлх эмчид орон нутгийн нэмэгдэл 40 хувийг сар бүр олгосугай.

2.Шаардагдах зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулахыг Эрүүл мэндийн төв (Х.Ганбат)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД